

ШИНЖЛЭХ УХААН,  
СОЁЛ

**МОНГОЛ, ЗӨВЛӨЛТИЙН  
ЭРДЭМТДЭЭС ЭНЭТХЭГИЙН  
ФИЛОСОФИЙГ СУДАЛЖ БАЙГАА НЬ**

**С. Норовсамбуу**

Энэтхэг орон, энэтхэгийн авьяас билэгт ард түмэн бол хүн төрөлхтний эд өлгийн болон оюуны соёлын хөгжилд дорвитой хувь нэмрийг оруулсан, дэлхийн соёл иргэншлийн ууган гал голомтын нэг мөн билээ. Энэтхэгийн хөдөлмөрч түмний ур ухаан, бүтээлч гараар сүндэрлэн боссон түүх-соёлын дурсгалт зүйлийн дотор энэтхэгийн төдийгүй, нийт хүн төрөлхтний соёлын эрдэнэсийн санд зүй ёсоор орж, мөнхрөн үлдсэн нь ч цөөнгүй бий. Эртний алдар суут Хараппын болон Мохенджо-Дарогийн иргэншлээс эхлээд Ашокийн багана бичээс, Таж-Махгалын сүм тэргүүтэн, Ведийн алдарт дууллаудаас эхлээд Махабхрата, Рамаяна, Панчатантра тэргүүтэн найраглалууд, Калидаса, Дандинаас эхлээд Рабиндранат Тагорын шүлэг дууллууд, эртний энэтхэгийн математик, одон орон судлал, хэл шинжлэлийн ололт амжилт энэ бүхэн бол нийт хүн төрөлхтний бахархал мөн. Тийм ч учраас Ф. Шиллер, В. Гюго, Р. Роллан, И. Кант, Г. В. Ф. Гегель, В. Г. Белинский, Л. Н. Толстой, С. Ф. Ольденбург, Ф. И. Щербатской, Н. Рерих зэрэг томоохон сэтгэгч, эрдэмтэн Энэтхэгийн соёлыг судалж, өндрөөр үнэлж байсан нь илэрхий билээ.

Өнөөгийн Энэтхэг улс аж үйлдвэрийн болон шинжлэх ухаан соёлын хувьд өндөр хөгжилтэй, дэлхий дахины, ялангуяа Ази-Номхон далайн бүс нутгийн энх тайван, аюулгүй байдал, хамтын ажиллагааны тэмцэлд зонхилох үүргийн нэгийг гүйцэтгэж буй, дэлхийн томоохон гүрний нэг мөн билээ. Энэ орны өнөөгийн нийгэм-соёлын олон үйл явдлыг өмнөх үегүйгээр, энэтхэгийн соёл-шинжлэх ухаан болон үзэл санааны уламжлалгүйгээр бүрэн гүйцэд ухаарахуйаа бэрх юм. Махатма Ганди, Дж. Неру зэрэг орчин үеийн энэтхэгийн нийгэм-улс төрийн томоохон зүтгэлтэн, Вивекананда, Ауробиндо Гхоша, С. Радхакришнан зэрэг сэтгэгчийн үзэл санаа бүрэлдэн тогтоход, ер нь орчин үеийн энэтхэгийн нийгмийн оюуны амьдралын төлөвшил хөгжилд энэтхэгийн уламжлалт соёл, үзэл санааны уламжлалт чиглэлүүд үлэмжхэн нөлөөлсөн нь нэгэнт илэрхий билээ.

Энэ бүхнээс үндэслэн үзэхүл, энэтхэгийн соёл, тухайлан түүний «хамгийн нарийн нандин, үнэ цэнэтэй бөгөөд үл ажиглагдам сор шим», «голт зүрхэн»<sup>1</sup> болсон философийн сэтгэлгээг улираан судлах талаар монгол, зөвлөлтийн эрдэмтдээс нэлээд анхаарсаар ирсэн нь бүрнээ ойлгомжтой хэрэг, Шинжлэх ухаан-танин мэдэхүйн болон улс төр-үзэл суртлын учир холбогдол бүхий тулгам зорилт, манай улс орнуудад өрнөн буй социалист соёлын байгуулалтын диалектик нэгэн шаардлага болж байгаа юм.

Түүнээс гадна энэтхэгийн философийг судлах явдал бидэнд, Монголын эрдэмтдэд өөр нэгэн шалтгааны улмаас ихээхэн ойр дотно байдаг юм. Тухайлан өгүүлбээс, эртний энэтхэгийн соёл, шинжлэх ухааны ололт буддын шашнаар дамжин монголд хүчтэй нөлөөлсөн би-

лээ. Монголын хөдөлмөрчин ард түмэн буддын соёл, эрдэм ухааны зүйлийг өвлөн авч, хадгалан үлдээх, цааш залгамжлан хөгжүүлэх талаар үлэмжхэн зүйлийг хийсэн юм. Нагаржуна ба Арьядэва, Асанга ба Васубандху, Дигнага ба Дхармакирти, Арьяшура ба Буддхагоша зэрэг эртний болон дундад эртний Энэтхэгийн буддын томоохон сэтгэгчийн зохиол туурвил Монгол оронд Монгол, төвд хэлээр бүрэн бүтнээрээ хадгалагдаж байгаа юм. Эдгээрийн дотор эдүгээ уг эх самгарьд хэлээрээ бидний үед хүрч ирээгүй, үрэгдсэн ховор нандин судар шастир ч цөөнгүй буй болно. Энэ бол Монголын нүүдэлч малчдаас нийт хүн төрөлхтний соёл иргэншилд оруулсан нэгэн томоохон хувь нэмэр даруй мөн гэж үзэх бүрэн үндэстэй юм.

Манай эрдэмтдээс энэтхэгийн соёл, түүнээс монголын утга зохиолын хөгжилд үзүүлсэн нөлөөг судлах талаар нэлээд зүйлийг хийсэн юм. Үүнд: акад. Б. Ринчин, Ш. Лувсанвандан, Ц.Дамдинсүрэн, Ш. Нацагдорж, Ш. Бира зэрэг эрдэмтний зохиол бүтээлийг юуны өмнө дурдвас зохино. Тухайлбал, акад. Ц. Дамдинсүрэн «Рамаяна Монголд», «Панчатантрын төвд, монгол өгүүллэгүүдийн цоморлиг», «Ардыг тэжээхүй рашааны дусал ба түүний тайлбар чандманийн чимэг зохиолын тухай», Дандины «Зохист аялгууны толь» ба түүний тайлбаруудын тухай товч мэдээ» зэрэг бүтээлдээ монгол, энэтхэгийн уран зохиолын харилцаа холбооны зарим чухал асуудлыг судлан авч үзээд, Энэтхэгийн уран зохиолын дурсгалуудаас малчин монголчуудын амьдрал, ахуйд хэрхэн идээшин зохиож, “монголжиж», тус орны оюун санааны амьдралын хүртээл болж ирснийг судалгааны баялаг эх материалаар товчлож харуулсан болно.<sup>2</sup>

Түүнчлэн акад. Ш. Бира «Монголын төвд хэлт түүхийн утга зохиол», «БНМАУ-ын түүх, соёл, түүх бичлэгийн асуудалд», «Дандины зохист аялгууны толь», «Самгарьд хэл шинжлэлийн бүтээлүүдийн монгол, төвд орчуулгуудын тухай», «Төв Азийн соёл иргэншлийн түүхэн дэх нүүдэлчин ард түмнүүдийн ролийн тухай», «Монгол, Энэтхэгийн түүх, соёлын харилцааны тухай» зэрэг бүтээлдээ монгол, энэтхэгийн түүх, соёлын уламжлалт хэлхээ холбоо, ялангуяа буддын түүх зүй монгол түүх бичлэгт уламжлагдан нөлөөлж, гүнзгийрэн хөгжиж ирсэн байдлыг нарийвчлан судалж харуулсан болно.

Энд манай эрдэмтдээс энэтхэгийн философийн түүхийг судалж байгаа тухай тусгайлан өгүүлэе.

Энэтхэгийн буддын философи, түүний Монгол орноо уламжлагдан хөгжсөн байдлыг ШУА-ийн сурвалжлагч гишүүн Ч. Жүгдэр агсан тусгайлан шинжилсэн юм. Тэрбээр «XIX—XX зууны зааг дахь монголын философи, нийгэм-улс төрийн сэтгэлгээний хөгжилт», «3. Агваанбалдангийн гүн ухааны үзэл», «XV—XVIII зууны Монголын гүн ухааны ба нийгэм улс-төрийн сэтгэлгээний хөгжлийн түүхэн тойм» зэрэг нэгэн сэдэвт зохиолууддаа буддын философийн асуудлуудаар монгол сэтгэгчдийн туурвисан шастир зохиолуудыг нягтлан шинжлэх үндсэн дээр энэтхэгийн буддын философи монгол оронд дэлгэрэн хөгжсөн түүхэн тоймыг сэргээн босгож, түүний үндсэн үе шатуудыг тодорхойлон гаргасан байна.<sup>4</sup> Доктор Ч. Жүгдэрийн дүгнэснээр Монгол оронд буддын философи нь тайлбарлагчдын ба шинэтгэгчдийн хэмээх хоёр шатыг дамжиж хөгжсөн болно. Үүнд: тайлбарлагчдын шатнаа халхын зая бандид Лувсанпэрэнлээ (1642—1716), дээд монголын эрдэнэ бандид сүмбэ хамба Ишбалжир (1704—1788), Лувсандагва-

даржаа (1734 — 1803), цахар гэвш Лувсанчүлтэм (1740—1810) зэрэг олон томоохон сэтгэгч төрөн гарч буддын философи, логикийн үндсэн урсгал, чиглэлүүдийн эх үндсийг тавьсан, цааш хөгжүүлэн болвсруулсан эртний Энэтхэгийн болон төвдийн нэрт сэтгэгчдийн зохиол бүтээлүүдийг нарийвчлан судалж, түүний хамгийн хүнд хэцүү, маргаантай асуудлыг дэлгэрүүлэн тайлбарласан ном зохиол туурвиж байсан байна. Харин XVII зууны эцэс XX зууны эхнээс эхлэн манай сэтгэгчид буддын философи, логикийн нарийн төвөгтэй асуудлуудыг судлан боловсруулж биеэ даасан судлал зохиолууд бичих, мөн ч буддын философийг тухайн цаг үеийнхээ өвөрмөц нөхцөл лүгээ холбон гүнзгийрүүлж боловсруулахаар оролдолхийлэх болсон байна. Энэ үеийг доктор Жүгдэр монголын буддын философийн хөгжил дэх «шинэтгэгчдийн үе» гэж томъёолон нэрлэсэн бөгөөд энэ үеийг, түүний нэгэн томоохон төлөөлөгч, Монголын буддын нэрт философич, цорж Агваанбалдангийн (1797—1864) үзэл санаагаар төлөөлүүлэн тусгайлж судалсан болно.

Түүнчлэн мөн энэ үед хамаарах монголын томоохон сэтгэгч алшаа лхарамба Агваандандар (1758—1830), говийн эрдэнэ ноён хутагт Данзанравжаа (1803—1856) нарын философи, нийгэм-улс төрийн болон логикийн үзэл санааны талаар тусгайлсан судалгаа хийгдэж, зарим үр дүн гарч байгаа юм.

Эдгээр судалгаа нь буддын философи, логикийн зарим тодорхой асуудлыг монгол сэтгэгчдийн зохиол бүтээлийн жишээн дээр тодруулан авч үзэж байгаагаараа Монголын төдийгүй, нийт энэтхэгийн буддын судлалд ч холбогдож байгаа юм гэж үзэж байна.

ШУА-ийн Философи, социологи, эрхийн хүрээлэнгээс эрхлэн «Буддын философийн түүхээс»<sup>5</sup> хамтын бүтээл нийтлүүлэв. Энэхүү бүтээлд Нагаржуна, Арьядэва, Чандракирти, Асанга, Васубандху, Стирамати, Дигнага, Дхармакирти зэрэг эртний Энэтхэгийн (буддын) гарамгай сэтгэгчдийн монгол Данжуур дахь бүтээлүүдийг тусгайлж нарийвчлан судлах үндсэн дээр буддын философийн үндсэн чиглэлүүд, үүнд, тайлбартны үзэл, дундад үзэл болон сэтгэлийн төдийтний үзлийн философийн зарим гол баримтлал, зарчмуудыг дэлгэрүүлэн авч үзэж, буддын логикийг тусгайлан судалж харуулсан болно. Тухайлан өгүүлбээс, буддын тайлбартны философи дахь дхармын онол болон махбодын тухай сургаал, дундад буюу төв үзэл дэх шүтэн барилдахын зарчим, хоосон чанарын үзэл санаа, сэтгэлийн төдийтний философи дахь хоёр үгүйн үзэл, гурван мөн чанарын сургаал хийгээд танин барихуйн үе шат, хэлбэрийн асуудал, буддын логик дахь баталгаа, няцаалтын асуудлуудыг авч тавьж боловсруулсан юм. Уг хамтын бүтээлийн үргэлжлэл болгож, түүнд авч үзсэн буддын философи, логикийн урсгал чиглэлүүд Монгол орноо дэлгэрч хөгжсөн байдал, ерөөс монголын философийн эх бичиг судлал, үзэл санааны үндсэн чиглэлүүд, зарим томоохон сэтгэгчийн үзэл сургаал зэргийг судлан тодорхойлохыг оролдсон «Монголын философийн түүхийн зарим асуудал»<sup>6</sup> хэмээх хамтын сэдэвчилсэн эмхэтгэл нэгэн дэвтрийг хэвлэлд шилжүүлээд байна.

Буддын философийн үндсэн чиглэлүүдийг авч үзэхдээ манай эрдэмтэд ялангуяа түүний зонхилох төв чиглэл болсон мадхьямака хэмээх дундад үзэл, түүнийг үндэслэгч эртний Энэтхэгийн гарамгай сэтгэгч Нагаржунагийн үзэл санааг судлан боловсруулахад үлэмжжэн

анхаардаг. Чухамхүү эл мадхьямака сургаал Монголын сэтгэгчдэд үлэмж хүчтэй нөлөөлж, гүнзгий ул мөрөө үлдээсэн учраас энэ нь ч зүй ёсны хэрэг юм. Ер нь ч мадхьямака үзэл бол буддизмаар зогсохгүй, тухайн үеэ хүртэл хөгжиж ирсэн нийт энэтхэгийн философи сэтгэхүйг шинжлэн гүн нарийн диалектик онолыг боловсруулсан энэтхэгийн философийн томоохон ололт, түүний хөгжилд онцгой байрыг эзлэх нэгэн сургаал даруй мөн болно.

Мадхьямака философийн талаар акад. Ш. Лувсанвандан, эрдэмтэн Г. Лувсанцэрэн нар нэлээд нарийн судалгаа хийсэн юм. Үүнд, акад Ш. Лувсанвандан Нагаржунагийн «Мадхьямакакарика» зохиол дахь найман үгүйсгэлийг нягтлан шинжлэх үндсэн дээр тэдгээр нь хамаг бүхний үндэс болсон номын бие, нирваны байдлыг үзүүлж, хос хосоороо чанар, цаг, орон, тооны харьцааг илэрхийлсэн байна гэсэн дүгнэлт<sup>7</sup> хийжээ. Тэгэхдээ ертөнцийг статик болон динамик талаас нь, эсрэг тэсрэгийн зөрчилт нэгдэлд нь авч үзсэн, угтаа аливаа бүхний оршин эвдрэхийн тойм загвар мөн гэж нотлоод хоосон чанарын онолыг Гегелийн гурвал, Нильс Борын квантын сургаал дахь нөхөх зарчмын томъёолол лугаа утга санааны хувьд тохирох болно гэдгийг задлан шинжилж гаргасан юм.

Г. Лувсанцэрэн Нагаржунагийн философийн үзлийг тусгайлан судалж бичсэн нэгэн сэдэвт бүтээлдээ<sup>8</sup> түүний философийн гол зохиолуудын агуулгыг хураангуйлан тодорхойлж, «Хоосон чанарын далан шүлэгт» зохиолыг нь нягтлан шинжлэх үндсэн дээр Нагаржунагийн философийн ашигтай үр болсон түүний хоосон чанарын тусгай хийгээд ерөнхий, харьцангуй хийгээд үнэмлэхүй, эмпирик хийгээд рациональ, тодорхой хийгээд хийсвэрийн диалектикийн үүднээс, тэдгээрийн нэгдэл болгон авч үзвэл илүү тодорхой бөгөөд зөв ойлгогдох болно гэж дүгнэсэн байна. Тийнхүү юмсын тогтнон хөгжих аль нэгэн талыг үнэмлэхүй болгон үзэх өрөөсгөл номлол, сэтгэхүйн метафизик хандлагын эсрэг Нагаржуна тууштай тэмцэж, ертөнцийг харилцан үйлчлэл, шүтэлцсэн холбоо харилцаа, хувьсал хөгжил дунд нь, жинхэнэ байгаа байдлаар нь танин барьсан гүнзгий диалектикч сэтгэгч байжээ гэж дүгнээд энэ талаархи үндэслэлүүдээ дэвшүүлж тавьсан юм.

Түүнчлэн буддын философийн йогачара чиглэл, буддын логик болон билэг барамидын сургаал, буддын одон зурхай зэрэг мэдлэг ухааны асуудлуудаар судалгаа хийгдэн эхэлж байна. Буддизмын антропологийн асуудлыг эрдэмтэн Д. Дагвадорж улираан судалж түүний асуудлаар эртний энэтхэг, төвд, монголын сэтгэгчдийн туурвисан зохиолууд, ялангуяа Зонхавагийн (XIV зуун) «Бодь мөрийн зэрэг» хэмээх их хөлгөн судрыг нягтлан шинжлэх үндсэн дээр «Хүний тухай шарын шашны үзэл» (УБ., 1983) гэдэг нэгэн сэдэвт зохиол бичжээ.

Манай эрдэмтдээс, буддын философи, логикийн асуудлуудыг судлан авч үзэхдээ буддизмын дотор нэг талаас шинжлэх ухааны сэтгэлгээ, соёлын ололт, тухайлан буддын философи, нөгөө талаас шашны хэвшмэл номлол хоёрыг зааглан үзэж, философи, логикийн ашигтай үрийг гарган харуулах, энэ үндсэн дээрээ сэтгэхүйн уламжлагдан хөгжиж ирсэн түүхэн явцыг мөшгин гаргах методологийг гол болгон баримталж байгаа юм. Үүнд, өнөөгийн БНМАУ дахь буддын философи судлалын методологийн нэгэн гол нэгдмэл баримтлал оршиж байгаа юм гэдгийг тэмдэглэж хэлэхийг хүсэж байна.

Зөвлөлтийн эрдэмтэд энэтхэгийн философи судлал, ялангуяа буддын судлалын баялаг өв уламжлалтай билээ. Бүр энэ зууны эхээр акад. Ф. И. Щербатской, С. Ф. Ольденбург нарын тэргүүлсэн орос зөвлөлтийн буддын судлалын сонгодог сургуультаан бий болсон нь буддын философи, логикийн олон чухал асуудлаар тэдний хийсэн дүгнэлт, дэвшүүлсэн концепци, баримтлалуудаас<sup>9</sup> буддын судлал эдүгээ ч зарим талаар даван хөгжиж төдийлөн чадаагүй байгаа болно.

Хэдий тийм боловч энэтхэгийн философийн түүхийг жинхэнэ шинжлэх ухаанч байр сууринаас өргөнөөр судлах ажил ЗХУ-д зөвхөн 1950-1960-аад оноос эрчимтэй өрнөж эхэлсэн билээ. Сүүлийн жилүүдэд энэтхэгийн соёл, шинжлэх ухааны баялаг өв сан, түүний дотор философийн сэтгэлгээний уламжлалыг задлан шинжлэх талаар зөвлөлтийн эрдэмтэд багагүй хүч чармайлт гаргаж, зарим томоохон үр дүнд хүрч байгаа юм. Одоо Зөвлөлтийн философич-энэтхэг судлалчдын судалгааны зарим үндсэн чиглэл, үр дүнг тоймчлон авч үзье.

Зөвлөлтийн эрдэмтдээс юуны өмнө Энэтхэгийн философийн хэд хэдэн чухал дурсгалт бичгүүдийг орос хэлнээ хөрвүүлэн нийтэлсэн юм. Тухайлбал, энэтхэгийн философийн эхэн үе болсон Ведийн судар дуоллуудаас нэлээдийг орчуулсан байна. Үүнд, Атхарваведа, Ригведа, Упанишадын дуоллууд, Брахман, Араньякын судруудаас Т. Елизаренкова, А. Я. Сыркин, В. В. Бродов зэрэг судлагч түүвэрлэн орчуулж тайлбар, зүүлт, удиртгалын хамтаар хэвлүүлсэн байна.<sup>10</sup> Энэтхэгийн философийн туульсын үед хамаарах Махабхрата, Рамайна, Бхававадгита зэрэг туулийн томоохон зохиолуудыг В. С. Семенцов, В. И. Кальянов, Б.Л. Смирнов зэрэг судлагч орчуулан хэвлүүлсэн юм. Энэтхэгийн эртний нийгэм-улс төрийн сэтгэлгээний чухал дурсгал «Манугийн хуулиудыг» С. Д. Эльманович, «Артхашастра» зохиолыг В.И. Кальянов нар тус тус орчуулж нийтлүүлжээ.<sup>12</sup>

Түүнчлэн эртний болон дундад эртний Энэтхэгийн философийн үндсэн чиглэлүүдийн зарим эх сурвалжаас орчуулах ажил хийгдэж байна. Энд ялангуяа эртний Энэтхэгийн буддын томоохон сэтгэгчийн нэг Васубандхугийн (IV зуун) «Илт номын сан» зохиолыг тайлбарын нь хамтаар бүрэн орчуулах ажил явагдаж байгааг онцлон дурдах хэрэгтэй юм.<sup>13</sup>

Эцэст нь орчин үеийн энэтхэгийн нийгэм-улс төрийн томоохон зүтгэлтэн М. Ганди, Дж. Неру нарын зохиол бүтээлээс орос хэлнээ нэлээд өргөнөөр хэвлүүлэн нийтэлжээ.<sup>14</sup>

Орчуулгын эдгээр ажил нь энэтхэгийн философи судлалыг эх бичиг судлалын материаллаг баазаар ханган өгч байгаа төдийгүй, уг сурвалж бичгийн агуулга, үзэл санааны эх сурвалж хийгээд түүний цааш уламжлагдан хөгжсөн байдал зэргийг задлан шинжилсэн удиртгал, тайлбар сэлтийг хавсаргаснаараа судалгааны үлэмж ач холбогдол бүхий бие даасан судлал бүтээлүүд болж байгаа юм.

Үүнтэй холбогдуулан тэмдэглэхэд, энэтхэгийн философийн асуудлаар гадаадын, ялангуяа энэтхэгийн өөрийн нь эрдэмтдийн туурвисан дорвитой бүтээлүүдийг хөрвүүлэн, орчуулагчийн тайлбар, дүгнэлтийн хамтаар хэвлэхэд ЗХУ-д ихээхэн анхаарч ирсэн байна. Тэгээд ч Радхакришнан С., Рой М., Чаттерджи С., Датта Д., Чаттопадхьяя Д. зэрэг эрдэмтний 10 гаруй зохиолыг чингэж нийтэлсэн болно.<sup>15</sup> Энэ бүхэн энэтхэг судлалын сүүлийн үеийн гол гол ололт амжилтыг уншигч

олон түмэнд танилцуулах болон судалгааг дэлхийн энэтхэг судлалын өнөөгийн тэргүүн түвшинд явуулах нэн чухал нэг нөхцөл болж байгаа юм.

Энэтхэгийн философийн үндсэн чиглэлүүдээс веданта, вайшешика, буддизм, джайнизм зэрэг түүний томоохон сургуулиудын үүсэл хөгжил, үзэл санааг улираан судлах талаар зөвлөлтийн эрдэмтэд ихээхэн зүйлийг хийгээд байна. Тухайлбал, Е. И. Гостеева, В. Г. Лысенко зэрэг судлагч вайшешика философи, түүний атомлаг үзэл онолыг нарийвчилж судалсан,<sup>16</sup> Н. Р. Гусева энэтхэгийн философийн джайнизмын болон индуизмын чиглэлийг судалж нэгэн сэдэвт зохиол бичсэн байна.<sup>17</sup> Доктор В. С. Костюченко эртний, дундад эртний болон шинэ үеийн ведантын философи, түүний үзэл санааны хувьсал хөгжлийг нягтлан судалж хэд хэдэн нэгэн сэдэвт зохиол бичсэн бол тус чиглэлийн том төлөөлөгч, эртний энэтхэгийн нэрт сэтгэгч Шанкарагийн үзэл сургаалыг Н. В. Исаева дундад эртний энэтхэгийн нийгэм дэх үзэл санааны тэмцлийн үүднээс шинжлэн дүгнэсэн байна.<sup>19</sup> Жоль К., Андросов В. П., Рудой В. И., Лучина В. И., Кутасова И. И. зэрэг судлагч буддын философийн зарим сэтгэгч, зарим чухал сурвалж зохиолын талаар судалгаа хийжээ.<sup>20</sup> Тийнхүү эртний болон дундад эртний Энэтхэгийн философийн үндсэн урсгал чиглэлүүдийн марксист-ленинист аргазүйн үүднээс тусгайлан судалж дүгнэх эх үндсийг тавьсанд эдгээр эрдэмтний судалгаа бүтээлийн ач холбогдол оршиж байгаа юм.

Зөвлөлтийн энэтхэг судлалын томоохон төлөөлөгчийн нэг нь акад. Бонгард-левин Г. М. мөн юм. Тэрбээр энэтхэгийн түүх, соёлын зангилгаа асуудлуудаар тулгуур судалгаа явуулж хэд хэдэн дорвитой бүтээл туурвисан юм. Акад. Бонгард-левин зохиол бүтээлдээ эртний болон дундад эртний энэтхэг орны нийгэм-эдийн засгийн байгууллын мөн чанар, онцлогийг товойлгон гаргах үндсэн дээр түүний шашны системүүд, философийн урсгал чиглэлүүд<sup>21</sup> болон шинжлэх ухааны салбаруудын<sup>22</sup> үүсэл хөгжлийг цогцолбороор судлан авч үзсэн байна. Тэрбээр судалгааны баялаг эх материал дээр үндэслэн оюуны соёлын салбар дахь энэтхэгийн ард түмний ололт амжилтыг товойлгон гаргаад энэтхэгийн нийгэм, түүний оюуны амьдрал эцсийн дүндээ нийт хүн төрөлхтний соёлын нийтлэг зүй тогтлуудын дагуу хөгжиж ирсэн болохыг нотолж үзүүлсэн болно.

Акад. Г. Ф. Александров эртний дорно дахины нийгмийн сэтгэлгээний хөгжлийн тухай тулгуур бүтээлдээ<sup>23</sup> энэтхэгийн ард түмний нийгэм-улс төрийн үзэл санааны хөгжлийг нэлээд анхааран авч үзсэн юм. Академич судалгаандаа Вед шастируудын болон ведант, джайнизм, буддизм зэрэг энэтхэгийн философи сэтгэлгээний зонхилох чиглэлүүдийн нийгэм-улс төрийн үзэл санааг задлан шинжилж, тэдгээрийн ололттой дэвшилттэй болон түүхэн хязгаарлагдмал талуудыг нягтлан тодорхойлж гаргах үндсэн дээр эртний энэтхэгийн сэтгэгчдээс нийгэм улс төр, зан суртахууны асуудлыг дан ганц шашин-идеализмын үүднээс тайлбарлаж ирсэн бус, бас ч нийгэм-улс төрийн материалист, рационалист үзэл санааны зохих үр хөврөл агуулагдан хөгжсөөр ирсэн бөгөөд чухамхүү ийм үзэл санаа нь нийгмийн хөгжил дэвшлийн хэрэгцээ, эрх ашгийг эцсийн дүндээ тусган илэрхийлж байсан болохыг нээж харуулсан болно.

Эртний болон дундад эртний Энэтхэгийн философи дахь материализмын өв уламжлалын асуудлыг проф. Н. П. Аникеев тусгайлан судалжээ.

Тэрбээр дурдан буй үеийн энэтхэгийн сэтгэлгээ дан ганц шашин, спиритуализмын үзэл санаагаар хязгаарлагдаж байсан биш, харин ч материализм, рационализмын баялаг өв уламжлалтай байж, энэтхэгийн философи дахь жинхэнэ ашигтай, ололттой үзэл санаанууд нь чухамхүү материализмын хүрээнд боловсрон хөгжиж ирсэн болохыг нотолж үзүүлсэн байна. Эл бүхий байдлыг тэрбээр санхья философийн үзэл санаагаар тодруулан авч үзсэн юм. Түүний сацуу идеалист урсгал чиглэлүүдийг энэтхэгийн философийн түүхэнд ямар нэгэн ашигтай зүйлийг огт хийгээгүй мэтээр өрөөсгөл үзэж болохгүй юм гэдгийг Н. П. Аникеев басхүү тодорхойлж гаргасан юм. Тухайлбал, дурдан буй үеийн энэтхэгийн философид сэтгэхүйн диалектик аргыг чухамхүү идеалист чиглэлийн үзэл сургаалууд голлон боловсруулж байсан бөгөөд үүнд ч тэдний нэн хүчтэй тал оршиж байлаа<sup>24</sup> гэж Н. П. Аникеев дүгнэсэн байна.

Орчин үеийн энэтхэгийн философийн асуудлаар доктор А. Д. Литман судалгаа хийж, хэд хэдэн томоохон бүтээл туурвижээ. Махатма Ганди, Дж. Неру болон Дев Атма, С. Радхакришнан, Р. Тагор, Ауробиада Гхоша, С. Абхедананда, П. Т. Раджа зэрэг орчин үеийн энэтхэгийн томоохон сэтгэгчдийн үзэл санааг задлан шинжлэх үндсэн дээр А. Д. Литман өнөөгийн Энэтхэгийн философи нь нэг талаар, үзэл санааны олон урсгал чиглэлийг багтаасан, нөгөө талаар, онтологи, гносеологийн болон социологи, этик, эстетик, логик, психологи зэрэг философийн мэдлэгийн бараг бүх чиглэлийг хамарсан өргөн дэлгэр агуулгатай бөгөөд шинжлэх ухаан-техникийн хувьсгалын одоогийн эрин үед зохицсон үзэл санааны хамгийн зүй зохистой системийг идэвхтэй эрэн хайж буй түүхэн үзэгдэл мөн гэж дүгнэсэн<sup>25</sup> байна. Түүнчлэн орчин үеийн энэтхэгийн философичдод энэтхэгийн философийн уламжлалт чиглэлүүд, ялангуяа ведантын үзэл санаа хүчтэй нөлөөлсөөр байгааг тодорхойлсон юм.

Орчин үеийн энэтхэгийн философийн зарим асуудлаар Л. Р. Гордон-Полонская, Р. А. Ульяновский, О.В. Мартышин зэрэг эрдэмтэн судалгаа хийж, В. В. Бродов шинэ үеийн энэтхэгийн философийн тухай нэгэн сэдэвт зохиол нийтлүүлсэн<sup>26</sup> болно. Ингэхдээ тэрбээр дурдан буй үеийн энэтхэгийн томоохон сэтгэгчдийн үзэл санааг дундад эртний үеийн энэтхэгийн философийн уламжлалт урсгал чиглэлүүдийн үзэл сургаалтай нягт уялдуулан авч үзсэн юм.

Түүнчлэн өнөөгийн Ази, дорнодахины улс орнуудын нийгэм улс төрийн амьдрал дахь буддизмын үүрэг ролийг доктор В. И. Корнев судалж хэд хэдэн нэгэн сэдэвт зохиол нийтлүүлсэн юм. Тэрбээр зохиол бүтээлдээ: «буддизмын сургаалыг тогтолцоот хандлагын үүднээс авч үзэхүл, тэр нь объектив идеализмын философид үндэслэсэн логикийн битүү тогтолцоо мөн» гэж дүгнээд нийгмийн амьдрал дахь түүний үүрэг ролийг Азийн улс орнуудын нийгмийн байгуулал, улс төрийн бодлого, үзэл суртал зэрэгтэй нягт холбон авч үзэх үндсэн дээр өнөөгийн Ази дахины энх тайвны хөдөлгөөн, Азийн улс орнууд дахь ангийн тэмцэлд буддизм тухайн түүхэн өвөрмөц нөхцөл, ангийн хүчний харилцаа зэргээс шалтгаалан харилцан адилгүй үүрэг гүйцэтгэж ирсэн<sup>27</sup> болохыг нотолж харуулсан болно.

Эцэст нь, энэтхэгийн философи, шинжлэх ухааны ололт буддизмаар дамжин төв Азийн ард түмнүүдийн дундад зууны соёлд хэрхэн нөлөөлж ирсэн байдлыг судлан авч үзсэн хэд хэдэн эмхэтгэлийг сүү-

лийн жилүүдэд зөвлөлтийн эрдэмтэд бичиж нийтлүүлсэн байна. Чингэхдээ эдгээр эмхэтгэлд олон зууны турш буддын шашны далбаа халхавчтайгаар хөгжиж ирсэн буддын мэдлэг ухааны уламжлалт салбаруудыг саланги тусад нь бус, харин буддын философийн нэг нэгдмэл үндэслэлээр холбогдож нэгдсэн, дорнодахины улс түмний оюуны соёлын нэгэн нэгдмэл бүхэл үзэгдэл болох хувьд нь авч тавин судалж байгаа юм. Судалгааны ийм хандлагыг бид дэмжиж байна.

Энэ бүхнээс үзэхүл, энэтхэгийн философийг судлах талаар Монгол, Зөвлөлтийн эрдэмтдээс багагүй зүйлийг нэгэнт хийж, судалгааны зохих эх үндэс тавигдаж байгаа нь илэрхий байна. Цаашид эл бүхий судалгааг улам өргөжүүлэн гүнзгийрүүлэх, үүний тулд нарийн мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, давтан бэлтгэх ажлыг сайжруулах, эх бичиг судлалын ажлыг өргөжүүлэх, эл чиглэлээр тусгайлсан хэвлэлтэй болох зэрэг олон зүйл шаардлагатай байгаа юм. Түүнчлэн Энэтхэгийн эрдэмтэдтэй, ялангуяа буддын судлалын чиглэлээр ажил хэргийн нягт холбоо тогтоож, мэргэжилтэн, эрдэмтдээ урт, богино хугацаагаар харилцан томилж ажиллуулах, ном зохиол солилцох зэрэг хамтын ажиллагааны зохистой хэлбэрийг эрж олох, зохион байгуулах явдал чухал байна.

### ЭШ ТАТСАН НОМ ЗОХИОЛ

1. **К. Маркс и Ф. Энгельс**, Соч., 2-ое изд., т. 1, с. 105
2. **Дамдинсүрэн Ц.**, Ардыг тэжээхүй дусал нэрт шастир ба түүний тайлбар Чандманийн Чимэг, УБ., 1961; Ц. Дамдинсүрэн, «Рамаяна» в Монголии М, 1979; Дамдинсүрэн Ц., Монголын уран зохиолын харилцаа холбооны асуудал (өгүүллийн эмхэтгэл). УБ., 1987,
3. **Бира Ш.**, Вклад кочевых народов в историю цивилизации Центральной Азии (древние и средние века),—Информационный бюллетень (Международная ассоциация по изучению культуры Центральной Азии), вып. 9, М., 1985, с. 5— 12; Бира Ш. Дамдины «Зохист аялгууны толь» Монгол орчуулга тайлбарын хамт (хамтран зохиогч Х. Гаадан, О. Сүхбаатар), 4 УБ., 1982. Бира Ш, Монгольская тибетоязычная историческая литература (XVII—XIX). УБ., 1960.
4. **Жүгдэр Ч.**, XIX-XX зууны зааг дахь Монголын нийгэм-улс төр, философийн сэтгэлгээний хөгжилт УБ., 1972; Жүгдэр Ч, 3. Агваанбалдангийн гүн ухааны үзэл, УБ, 1978; Жүгдэр Ч., XV—XVIII зууны монголын нийгэм-улс төр, гүн ухааны сэтгэлгээний хөгжлийн түүхэн тойм, УБ., 1984.
5. Буддын философийн түүхээс (хамтын бүтээл), УБ., 1987,
6. Монголын философийн түүхийн зарим асуудал. (хэвлэлтэд),
7. **Лувсанвандан Ш.**, Мадхьямака хэмээх дундад үзэл—философийн эрхийн судлал, 1 боть, 10 дугаар дэвтэр, УБ, 1977; Лувсанвандан Ш., Фонемын онолын тухай асуудалд, — Хэл зохиол судлал, боть, 2 дугаар дэвтэр, УБ., 1969.
8. **Лувсанцэрэн Г.**, Нагаржунагийн философийн үзэл, УБ., 1981,
9. **Шербатской Ф. И.**, Избранные труды по буддизму. М., 1988,
10. Упанишады, Пер, **А. Я. Сыркина**. М., 1967; Атхарваведа, Избранное, Чхандогья унанишада, Пер, А. Я. Сыркина. М., 1965; Брихадараньяка унанишада, Пер. А. Я. Сыркина, М., 1964; Ригведа Избранные гимны Пер. комм. и вступ, статья Т. Я. Елизаренковой, М., 1972; Древнеиндийская философия. Начальный период. М., 1963
11. Махабхрата Кн. 1, Пер с санскрита и комм, В. И. Кальянова, М, 1958; Махабхрата, Вып. I-VII, Пер., введ., прим и толковой словарь Л. Б. Смирнова, Ашхабад, 1957—1963; Бхававадгита, Пер. с санскрита В. С. Семенова—Семенов В, С, Бхававадгита в традиции и в современной научной критике, М., 1985. —
12. Артахаштра или наука политики Каутили, Подготовил В. И. Кальянов, М-Л, 1959; Законы Ману, Пер. С. Д.Эльмапович, М, 1960,

13. Васубандху, Абхидхармакоша, Улан-Удэ, 1980,
14. **Неру Дж.**, Автобиография, М., 1955; Неру Дж, Взгляды на всемирную историю, т, 1—3, м, 1983; Неру Дж. , Открытие Индии, М., 1955; Моя жизнь, М, 1969,
15. **Радхакришнан С.**, Индийская философия, т. I—II, М., 1956; Рой М, История индийской философии, М., 1956; Чаттерджи С., Датта Д, Введение в индийскую философию М., 1955; Чаттопадхья Д. , Живое и мертвое в индийской философии, М., 1981,
16. **Гостеева Е. И.**, Философия ва йшешик, Ташкент, 1963; Лысенко Г. В.. . Атомизм школы вайшешика, Докт, дисс., М, 1981,
17. **Гусева Н. Р.** Джайнизм, М., 1968, Гусева Н, Р, Индуизм М, 1977
18. **Костюченко В. С.**, Вивеканда, М., 1977, Костюченко В. С., Классическая веданта и неоведантизм, М., 1983
19. **Исаева Н. В.** Из истории идейной борьбы в древней и раннесредневековой Ундии, канд. дисс, М, 1983,
20. **Жоль К. К.** Сравнительный анализ индийского логико-философского наследия, Киев, 1981, Андрасов В. П. Концепция ниришварада в Индийской философско-религиозной традиции, Канд, дисс, 1982. Кутасова И. И. Философия Нагарджуны, Канд. дисс, М, 1963,
21. Бонгард-левин Г. М., Древнеиндийская цивилизация, философия, религия, М, 1980, 156—208 дахь тал
22. Мөн зохиол. 208—242 дахь тал.
23. **Александров Г. Ф.** История социологических учений. Древний Восток, М. 1959, Александров Г. Ф. Очерки истории социальных идей в древней Индии, Минск, 1959.
24. **Аникеев Н. П.** О материалистических традициях в индийской философии, М, 1965, с. 128 — 199,
25. **Литман А. Д.** Современная индийская философия, М, 1985, с. 29.
26. **Бродов, В. В.**, Индийская философия нового времени, М., 1987.
27. **Корнев В. И.**, Буддизм и его роль в общественной жизни стран Азии М., 1983.

## **МОНГОЛЧУУДЫН ЭРТНИЙ СОЁЛ**

### **А. Дамдинсүрэн**

Та бидний өссөн төрсөн өлгий энэ Монгол нутаг бол өнө эрт үеэс эхлэн хүн төрөлхтний соёл иргэншил цогцлон бүрэлдэж буй болсон нэг том голомт юм. Түүнийг бүтээхийн тулд Монголчууд бидний өвөг Хүннү нар олон үеийн турш уйгагүй их хөдөлмөрлөн, оюун ухаан, хөлс цусаа үлэмж их асгаруулсан бартаат хэцүү зам туулан давж хүн төрөлхтний соёл иргэншлийн санд давтагдашгүй үнэт хувь нэмэр оруулан хойт үе бидэнд үүрд бахархан дурсаж явах сайхан өв үлдээсэн юм.

Энэ тухай гадаадын янз бүрийн орны эрдэмтэд, судлаачид Монгол оронд ирж Монголын уудам дэлгэр нутгийн хөрсөн доорхи болон дээрх түүх соёлын гайхамшигт дурсгалуудыг түүх, археологи, палеонтологи, геологи, угсаатан, хэл, утга зохиол, зан заншил, аж амьдралын байдлаар нь ангилан тал талаас нь нарийвчлан судалсан олон тооны ном, зохиолууд дэлхийн олон оронд янз бүрийн хэл дээр хэвлэгдэн гарсан билээ. Энэ олон эрдэмтэд, судлаачдын бичсэн судалгаа шинжилгээний ном зохиолд тулгуурлан үзвэл, Монгол оронд соёл иргэншил үүссэний